

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР
2025 оны эхний хагас жил**

2025 оны 06 сарын 25

Улаанбаатар хот

Д/д	Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжил тийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
ЗГ-ын тогтоол								
1.	103	200	Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорац байгуулах тухай 2024-10-02 Дугаар 2024_114	1.4. 1.4 Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд тус тус даалгасугай.	Шинэ Зуунмод хотын Захирагчийн ажлын албанд нийт 36.4 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийг НӨХГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/621 дүгээр тушаалаар балансаас баланст шилжүүлэн хөрөнгийг актаар хүлээлгэн өгсөн. Мөн Хан-Уул дүүрэгт байрлах Хангарди ордны Б блокт Захирагчийн ажлын албанд үйл ажиллагаа явуулах байр талбайгаар хангасан.	100%		
2.	155	284	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 61 дүгээр тэмдэглэл 2022-12-14 Дугаар 2022_61	XIX.1. “Соёлын төв өргөө”-ний ашиглалтын нөхцөл байдлын талаар Соёлын сайд Ч.Номин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Соёлын төв өргөө”-ний байрны өмчлөлийн асуудлыг судалж эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа танилцуулахыг Соёлын сайд Ч.Номин, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав.	НИХТ-ын 2025 оны Дугаар 25/26 тогтоолоор Нийслэлийн Соёлын төв өргөө төсөвт үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулж ОНӨААТҮГ хэлбэрт шилжүүлэн дүрмийг шинэчлэн баталсан. НИХТ-ын 2025 оны Дугаар 25/27 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/796 дугаар захирамжаар Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй нийт 9.5 тэрбум төгрөгийн анхны өртөг бүхий барилгыг Нийслэлийн Соёлын төв өргөө ОӨНААТҮГ-ын баланст шилжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025.02.20-ний өдрийн А/264 дүгээр захирамжаар "Нью тур сафарис" ХХК-	100%		

				ийн эзэмшиж байгаа Соёлын төв өргөөний "В" корпусыг нийслэлийн өмчид буцаан авах асуудлыг судалж хэлцэл хийх, санал танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.			
3.	159	289	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Балансаас баланст шилжүүлсэн тээврийн хэрэгсэл: - Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/274 дүгээр захирамжаар Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй 2.7 тэрбум төгрөгийн 10 автобусыг Нийтийн тээврийн бодлогын газарт, - Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/306 захирамжаар 6.7 тэрбум төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 59 нэр төрлийн тээврийн хэрэгслийг 11 байгууллагад.	100%	
4.		464		1.7.1.7.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А-1/702 дугаар бүхий "орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой нийт хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, судалгааны тоо баримтыг нэгтгэхэд шаардлагатай тоон мэдээлэл, танилцуулга ирүүлэх" албан бичгийн дагуу нийслэлийн 106 хуулийн этгээдийн 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсөвт төвлөрүүлсэн дүн, аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлтэй холбоотой болон хүний нөөц, хөрөнгө оруулалтын	100%	

				судалгааг нэгтгэн албан бичгээр хүргүүлсэн. 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор нийслэлийн өмчит 14 хуулийн этгээдүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийн өмчит компаниудыг зөвхөн биржээр дамжуулан олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох замаар өөрчлөх ажил судалгааны түвшинд явагдаж байна. Тус арга хэмжээний хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 оны 02 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулсан 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн Өмчийн газрын ажилтнуудад зориулсан сургалтад албан хаагчид хамрагдсан. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах, компанийн засаглалыг нэвтрүүлэх, удирдлага зохицуулалтын цахим систем нэвтрүүлэх, орон нутгийн өмчид тулгарч буй асуудлуудад дээд шатны байгууллагаас заавар зөвлөгөө авах зорилгоор төвийн бүсийн аймгуудын 2025 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулах сургалт зөвлөгөөнд 11 албан хаагчдыг хамруулсан. 2.Нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон			
--	--	--	--	--	--	--	--

					дэвшүүлэх хороод нээлттэй зохион байгуулж шалгаруулсан. Шалгарсан нэр дэвшигчдээр ХАСУМ бөглүүлэн АТГ-д хянуулан ашиг сонирхлын зөрчлийг хянуулж, зөрчилгүй хариу гарсан нэр дэвшигчдийг 2024.12.04, 2025.1.27, 2025.04.15, 2025.05.23-ны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн 24/87, 25/33, 25/62 дугаар тогтоолуудаар ТУЗ-ийн гишүүдийг томилж, чөлөөлсөн.			
--	--	--	--	--	--	--	--	--

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА

ХЯНАСАН: ЗУХ-ИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН: ЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т. Оюунтуул
М. Энхбаяр

Т. ОЮУНТУУЛ

М.ЭНХБАЯР